

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР

Өдөр +21  
Шөнө +10

ДЭЛХИЙ

ЭЭЛЖИТ ПАРЛАМЕНТЫН  
СОНГУУЛИЙГ ДЭЛХИЙ ИНГЭЖ  
ДҮГНЭЛЭЭ

VI нүүрт

ШУУРХАЙ МЭДЭЭ

“САЙН ХАШАА” ХӨТӨЛБӨРИЙН  
ЗЭЭЛИЙН 50 ХУВИЙГ УЛСААС  
ГАРГАНА

VII нүүрт

Дугаарын **60** мөр

СОНГУУЛЬ 2016

Залуучууд сайн  
байлаа

## МАН ҮНЭМЛЭХҮЙ ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА

Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын ээлжит сонгууль өчигдөр болж, санал хураалт 07:00-22:00 цагийн хооронд үргэлжилж, өндөрлөлөө. Өнөөдрөөс ялсан, ялагдсан нэр дэвшигчдийн нэрс тодорхой болно. Яах вэ, мэр сэр маргаан энэ тэр гарахыг үгүйсгэхгүй. За тэр ч яах вэ. Хамгийн гол нь энэ удаагийн сонгуульд залуус тун идэвхтэй оролцлоо. СЕХ санал хураалт дууссаны дараа өгсөн мэдээллээр бол улсын хэмжээнд сонгуулийн ирц 70 орчим хувьтай байлаа. Аль ч хэсгийн хороон дээр очсон 25-40 насныхан тун идэвхтэй саналаа өгч байгаа талаар ярьж байсан. Түүнчлэн 18-25 насны залуучууд ч идэвхтэй оролцлоо. Тэдний оролцоог үгүйсгэж болохгүй. Ерөөсөө улсын хэмжээнд энэ удаагийн сонгуулиар залуучуудын оролцоо өндөр байлаа.

Үргэлжлэл нь III нүүрт



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Ж.ОТГОН

УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын 2016 оны сонгуулийн санал хураалт өчигдөр өглөө 07:00 цагт улс орон даяар нэгэн зэрэг эхэлсэн. Энэ удаагийн УИХ-ын ээлжит сонгуульд 498, аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд 2288, нийт 2786 нэр дэвшигч өрсөлдсөн бөгөөд 1 912 901 сонгогч санал өгөхөөр сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн. Сонгогчид сонголтдоо хэрхэн хийж байгаа талаар СЕХ-оос цаг үеийн мэдээллийг 13:00, 18:00, 23:00 цагт ирцийн мэдээллийг өгч байлаа. Ингээд сонгуулийн өдөр ямар үйл явдал болж өрнөсөн талаар цаг, минуттай нь хүргэж байна.

11:30 цаг

Монгол Улсын иргэн бүр төрийн эрх барих 3 минутын эрхээ эдлэх учиртай. Төрийн өндөрлөгүүд ч мөн харьяа хороондоо очиж саналаа өгсөн.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## ЭРДЭНЭТИЙН 49 хувийн эргэн тойронд...

Б.ӨНӨРТӨГТОХ

Монгол түмэн өчигдөр Үндсэн хуулиар олгогдсон гурван минутын төр барих эрхээ эдэллээ. Өвгөд хөгшдийн хувьд энэ өдрийг баярын өдөр хэмээн боддог учраас гоёлын дээлээ өмсөж үр ачаа дагуулсаар санал өгсөн юм. Харин залуусын хувьд идэвх юу юунаас илүү байж, маргаашийнхаа ирээдүйн төлөө саналаа өгөв. Монголчууд тэр чигээрээ сонгуулиар амьсгалсан сүүлийн хоёр өдөрт Монгол Улсын “саалийн үнээ” гэгддэг Монгол, Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэр 100 хувь Монгол Улсын өмч болсон тухай мэдээлэл олны анхаарлыг татав. Монголчууд тэр тусмаа Эрдэнэт хотын амьжиргааны гол эх үүсвэр болсон энэхүү том үйлдвэрийг Монголын тал 51, ОХУ-

ын “Ростех” компани 49 хувийг эзэмшиж байв. Тэгвэл өнөөдрөөс эхлэн энэхүү том үйлдвэр 100 хувь Монголын талд ирлээ. Энэ талаарх яриа улс төрийн намуудаас гадна эдийн засагчдын анхаарлыг татаж, Эрдэнэт 100 хувь Монголын мэдэлд орсон нь зөв буруу гэх маргаан ч гараад амжлаа. Зарим эдийн засагчид Монгол Улсын эдийн засагт асар том өөрчлөлт авчрах болно хэмээн байр сууриа илэрхийлсэн бол нөгөө талд нэг банкинд өгсөн нь буруу Засгийн газар энэ хувийг эзэмших ёстой гэсэн байр суурийг ч илэрхийлэв. Зөв буруугийн тухайд эртлэн дүгнэлт хийх нь илүүц учраас Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Монголын талд шилжүүлсэн асуудлаар талуудын илэрхийлсэн байр суурийг тоймлон хүргэе.

Үргэлжлэл нь III нүүрт

**DELL**

**ЗӨВХӨН 6-Р САРД**

**КОМПЬЮТЕР ХУДАЛДАН  
АВСАН ХҮН БҮР  
9 БЭЛЭГТЭЙ  
ЭСВЭЛ**

**БОНУС КАРТ 5%  
урамшуулалтай**

Зөвхөн “DELL Center”-т  
Хаяг: Компьютер Ландын зүүн талд DELL Center  
Холбогдох утас: 9906-9493, 9904-2031

18 дахь жилдээ

**МОНГОЛЫН МЭДЭЭ**

Манай сонины III улирлын захиалга  
үргэлжилж байна

**Захиалгын үнэ  
15400**

Улиралд **44** дугаар

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк					
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах	
АМ.ДОЛЛАР	1958.00	1986.00	ФУНТ	2565.00	2667.00	АМ.ДОЛЛАР	1962.00	1985.00	
ЕВРО	2145.00	2216.00	РУБЛЬ	28.40	32.50	ЕВРО	2144.00	2220.00	
ИЕН	18.91	19.56	ЮАНЬ	292.50	299.80	ИЕН	18.99	19.72	
							ФУНТ	2580.00	2674.00
							РУБЛЬ	28.70	31.70
							ЮАНЬ	293.80	299.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

СОНГУУЛЬ 2016

# МАН ҮНЭМЛЭХҮЙ ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Тодруулбал, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 11:30 цагт Орос Ш сургуульд байрлах 59 дүгээр тойргийн зургадугаар хэсгийн хорооны санал авах хэсгийн хороонд гэргийтэйгээ очиж саналаа өглөө. Харин Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 12:30 цагт Удирдлагын академийн Б корпус байрлах УИХ-ын сонгуулийн 56 дугаар тойргийн гуравдугаар хэсгийн хороонд саналаа өгсөн бол УИХ-ын дарга З.Энхболд УИХ-ын сонгуулийн 59 дүгээр тойргийн VII хэсгийн хорооны санал авах байр буюу 45 дугаар сургуулийн санал авах байранд очиж саналаа өгөв. Түүнчлэн 12:00 цагт нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл 45 дугаар сургууль дээр, НИТХ-ын дарга Д.Баттулга сонгуулийн 59 дүгээр тойрог, нийслэлийн ИТХ-ын сонгуулийн 26 дугаар тойргийн 10 дугаар хэсгийн санал авах байранд очиж тус тус саналаа өглөө.

### 13:00 цаг

Нийслэлийн Сонгуулийн хорооноос санал хураалтын ирд, явцын талаар эхний мэдээллээ 13:00 цагт мэдээлэл өглөө. 12:00 цагийн байдлаар нийслэлийн 164449 сонгогч буюу нийт сонгогчдын 18.20 хувь нь саналаа өгөөд байв. Нийслэлийн есөн дүүргийн 397 санал авах байранд 3966 төрийн албан хаагч сонгуулийн ажлыг зохион байгуулсан юм. Нийт санал авах байруудын дотор болон гадна санал хураалтын үйл ажиллагааг



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хянах камеруудыг байрлуулсан бөгөөд нийт санал авах байрны 30 хувьд нь цахилгааны эх үүсвэрээр хангасан. Өнгөрсөн мягмар гарагт орсон хүчтэй борооны улмаас Багануур дүүрэгт нэг санал авах байр усанд автсан бөгөөд санал авах байрыг ойролцоох байранд шилжүүлж ажиллав. Энэ сарын 28-ны өдрийн 09:00-20:00 цагийн хооронд нийт 4691 иргэнээс зөвөрийн битүүмжилсэн хайрцагар санал авахаас 4412 сонгогчийн саналыг авсан талаар мэдээлсэн юм.

### 13:30 цаг

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн явцын мэдээллээ 13:30 цагт хийлээ. СЕХ-ны дарга хөдөө, орон нутагт сонгогчдын ирд зарим аймагт 20 гаруй, зарим аймаг 30 гаруй хувьтай байгаад дуулгасан юм. Улсын хэмжээнд хамгийн өндөр хувьтай буюу 40 гаруй хувиараа Сэлэнгэ аймаг Ч.Содномцэрэн “Хар машинтай холбоотой гомдол хэд хэдэн удаа ирсэн. Нэгдүгээрт, Өвөрхангай аймгийн Төгрөг суманд цахилгаан тасарснаас болж машин гацсан тохиолдол гарсан. Бид холбогдох байгууллагууд руу ярьж, цахилгааныг залгуулсан байгаа. Үүнээс гадна цахилгааны хэлбэлзлээс үүдэн Хан-Уул дүүрэг, Увс аймагт автومات машинууд гацсан тохиолдол гарсан. Үүнийг таслахгүй байх асуудлаар холбогдох байгууллагад анхааруулсан. Түүнчлэн, хар машинтай холбоотой хоёр ноцтой гомдол ирсэн. Тодруулбал, Сонгинохайрхан дүүргийн 71 дүгээр тойрог дээр нэг сонгогч саналын хайрцгийн лацыг хуулж, саналын хуудсыг машинд уншуулахгүйгээр шууд хайрцаг руу нь хийсэн тохиолдол гарсан. Энэхэргийг тагнуул, цагдаагийн байгууллага шуурхай ажиллан зогсоосон. Гэхдээ саналын хуудас нь хайрцаг руугаа орчихсон. Зогсоохын завдалгүй саналын хуудсаа хийсэн байсан. Яг нийм үйлдэл Баянгол дүүргийн 67 дугаар тойргийн 14 дүгээр санал авах байранд мөн гарсан. Хоёр өөр хүн уг хэргийг үйлдсэн. Санал хураах ажиллагааг зориуд будиулах зохион байгуулалттай оролдлого байж магадгүй гэж бид үзэж байгаа. Хууль хяналтын байгууллаагынхан энэ хэрэг дээр ажиллаж байна” хэмээсэн.

### 14:30 цаг

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр 14:30 цагт эхний мэдээллээ хийлээ. Тэрбээр мэдээллийнхээ үеэр олон хүн мөнгө тарааж, сонгогчдыг автобусаар зөөж байгаа талаар ярьсан бөгөөд МАН-аас нэр дэвшигч Д.Оюунхоролыг нэр дэвшигчдийн жагсаалтаас хасах шүүхийн шийдвэр гарсан

талаар хэллээ. Л.Эрхэмбаяр “Өчигдөр, өнөөдөр МАН-ын нэр дэвшигчид хууль бус үйлдлүүд маш ихээр гаргаж байгаа талаар манай сонгуулийн штабт мэдээлэл ирж байна. Тухайлбал, МАН-аас УИХ-ын сонгуулийн 33 дугаар тойрогт нэр дэвшигч Ч.Хүрэлбаатарын штабаас машинтай явж, их хэмжээний мөнгө тараах гэж байгаад баригдаж, одоо цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа талаар мэдээлэл ирсэн. Мөн Дорнод аймгийн 14 дүгээр тойрогт МАН-аас нэр дэвшигч Х.Болорчулууны штабаас сонгогчдыг зохион байгуулалттайгаар зөөж, Сонгуулийн хууль зөрчиж байгаа асуудлыг цагдаагийн байгууллага шалгаж байна. Түүнээс гадна, Архангай аймгийн гуравдугаар тойрогт МАН-аас нэр дэвшигч Ж.Мөнхбатын сонгуулийн сурталчилгааны хаалт дээр УИХ-ын дарга асан Х.Төмөр-Очир очиж, хууль зөрчсөн үйлдэл гаргасан. Өөрөөр хэлбэл, АН-аас нэр дэвшигч Р.Гончигдоржийн туслахыг хүн зодсон мэтээр илтэд гүтгэж гүжирдсэн, өрсөлдөгчийнхөө нэр хүндийг унагаж, хууль зөрчсөн үйлдлийг хаалтын үйл ажиллагаан дээр явсныг цагдаагийн байгууллага шалгаж байна. Мөн Оросын талын эзэмшдэг “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг Монголын ХХБ худалдан авч байгаа сайн мэдээг илтэд гуйвуулж эхэллээ. Нийт 1998 санал авах байрны үүдэнд очиж, хар муу талаас нь гуйвуулсан мэдээлэл өгч байгаа талаар олонгомдол манай намын Сонгуулийн төв штабт ирж байгаа. Сурталчилгааны хугацаа дууссаны дараа МАН, МАХН-ынхан “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой гүжир гүтгэлтийн шинжтэй сурталчилгаа явуулж, Сонгуулийн хуулийг ноцтой зөрчиж байгаа учраас АН хууль, хяналтын байгууллагад хандих болно” хэмээлээ.

### 15:00 цаг

Нийслэлийн Сонгуулийн хорооноос сонгуулийн санал хураалтын ирцийн мэдээг 15:00 цагийн байдлаар танилцууллаа. Нийслэлийн нийт сонгогчдын 311 283 буюу 36.9 хувь нь саналаа өгчээ. Нийслэлийн Сонгуулийн хороо дараагийн мэдээллээ 18:00 цагт өгнө гэдгээ энэ үеэр мэдэгдлээ.

### 15:30 цаг

Улс төрийн намуудын удирдлагууд өчигдөр СЕХ-д сум, дүүргийн сонгуулийн хороо санамсаргүй сонголт хийж, 50 хувьд хяналтын тооллого хийх шаардлага хүргүүлээ. Сонгуулийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.13-т “Санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо санамсаргүй сонголтын аргаар харьяа хэсгийн хорооноос 50 хүртэл хувийг сонгож, 24 цагийн дотор техникийн тооллого хийнэ. Техникийн

тооллогод сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн болон сонгогчдын төлөөллийг оролцуулна” гэж заасан байдаг. Түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооны “Техникийн тооллого хийх журам”-ын нэгдүгээр зүйлийн 1.2-т “Санал хураалт дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн санал авах байруудаас санамсаргүй сонгох аргаар 50 хүртэл хувийг сонгож, техникийн тооллого хийх тухай” тусгасан байдаг юм. Тэгвэл 50 хүртэл хувь гэдэг нь 10, 20, 30 гээд хэдэн ч хувийн тооллого хийж болно гэдгийг шаардлага хүргүүлсэн МАН, МАХН, БНН, МКН, ЭЧХН, МСДН, ИХН, ИЗНН, ТГЭНЭ гэх намын дарга нар ойлгоогүй байсан бололтой. Гэтэл зарим аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны удирдлага сонгуулийн хэсгийн хороодын дарга нарт техникийн тооллогыг санал авах байруудаас 10-20 хувьд нь хийх чиглэлийг өгсөн гэх мэдээлэл гарсан байна. Тиймээс сонгуульд оролцож байгаа улс төрийн нам, эвслийн төлөөлөл дээрх үүрэг чиглэлийг сонгууль будилаантуулах, үнэнээс зугтаах арга хэмээн үзэж байгаа аж.

### 15:40 цаг

МАН-ын сонгуулийн штабаас АН-ын мэдэгдлийн хариу мэдэгдлийг 15:40 цагт хийлээ. УИХ-ын гишүүн Су.Батболд багтлагдаж нотлогдоогүй асуудлаар Ардчилсан нам мэдээлэл хийж, зарим нэр дэвшигчийн эрхэнд халдлаа. Иймээс үнэн зөв бодитой мэдэгдлийг хийхээс аргагүй боллоо гэдгээ хэллээ. Тэрбээр “Архангай аймгийн Их тамир сумын сонгогчдод архи тараах гэж байна” гэсэн дуудлага цагдаагийн байгууллагад ирж, очиж шалгахад “УБМ” дугаартай автомашинд нэр дэвшигч Д.Ганхуягийн сонгуулийн сурталчилгаа, архи ачсан байсан. Энэ хэргийг аймгийн Цагдаагийн байгууллагад шалгаж байна. Архангай аймагт нэр дэвшин өрсөлдөж байгаа МАН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Мөнхбатын сонгуулийн сурталчилгааны хаалтын үйл ажиллагаанд УИХ-ын дарга асан Төмөр-Очир оролцохдоо “Р.Гончигдоржийн сонгуулийн штабынхан Ж.Мөнхбатын штабынханд халдсан” гэдэг зүйл ярьж хууль зөрчсөн гэсэн. Энэ асуудлыг бид утсаар ярьж тодруулахад “Ийм зүйл яриагүй” гэдэг тайлбар хийлээ. АН-ын ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр сонгуулийн сурталчилгаа явж байгаа энэ үед нэр дэвшигч Д.Оюунхоролын бүрэн эрхэд, нэр хүндэд халдсан ноцтой мэдэгдлийг хийлээ. Нэрийг нь татах хэмжээний ноцтой зөрчил гаргалаа гэсэн. Гэтэл Д.Оюунхорол нэр дэвшигчийн нэр дээр шүүхийн шийдвэр ирээгүй байгаа. Мөн Сонгуулийн ерөнхий хорооноос “Нэр дэвшигч Д.Оюунхоролыг нэр дэвшигчээс хасах шийдвэр

гаргаагүй” гэдэг тайлбарыг ирүүлсэн” гэж хэллээ. Мөн Увс аймагт нэр дэвшин өрсөлдөж байгаа УИХ-ын гишүүн Ч.Хүрэлбаатарын авто машин руу цагдаагийн байгууллага хууль бусаар нэвтэрч нэгжлэг хийсэн. Нэгжлэг хийх үед нь хувийн хэрэгцээний 200 мянган төгрөг байсан. Үүнийг нь биедээ их хэмжээний мөнгө авч явсан, түүнийгээ сонгогчдод тараах гэж байсан гэж сошиалаар хуурамч мэдээлэл тарааж ташаа ойлголт төрүүлж байгаад харамсч байна” гэдэг мэдээллийг хийлээ.

### 15:50 цаг

МАН-ынхан хэвлэлийн хурал хийсний дараа МАХН-ын зүгээс мөн хэвлэлийн хурал хийж хууль зөрчсөн асуудлаар мэдээлэл өгсөн юм. МАХН-ын дарга Н.Энхбаяр болон намын хэвлэл хариуцсан нарийн бичгийн дарга Б.Тулга, Багануур дүүргийн МАХН-ын дарга Ж.Батбаяр нар мэдээлэл хийлээ. Тодруулбал, Баянзүрх дүүрэгт МАН-ынхан бөглөсөн саналын хуудас тарааж байгаад баригдсан зөрчил илэрсэн тухай мэдээлэл туснамиржээ. Үүнээс гадна Эрдэнэт хотод АН-аас нэр дэвшч буй Д.Одхүү, Иргэний хөдөлгөөний намаас нэр дэвшигч Х.Золжаргал, МАН-ын нэр дэвшигч Д.Атармаа нарын аль нэг нь биднийг дэмжээрэй хэмээн 20 мянган төгрөг тарааж штаб УИХ-ын сонгуулийн 49 дүгээр тойрогтой холбоотой гүтгэлтийн чанартай мэдээлэл хийлээ” гэж МАН-аас үйлдсэн. Гэвч Сонгуулийн ерөнхий хорооноос “УИХ-ын сонгуулийн 49 дүгээр тойрогт нэр дэвшигч Д.Оюунхоролын шадар туслах Н.Энхзаяа нь хууль зөрчсөнийг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх тогтоосон. Шүүхийн шийдвэрийг дахин давж заалдах байгаа талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга хэллээ. Энэ бол шүүхийн шатандаа давж заалдаад явж байгаа хэрэг гэдэг нь нотлогдлоо. Бид гүтгээгүй нь батлагдлаа. Орон нутагт элдэв булхай гарсаар байгаа талаархи мэдээллийг Ардчилсан намын сонгуулийн төв штабт ирүүлсээр байна. УИХ-ын сонгуулийн 37 дугаар тойрог буюу Хөвсгөл аймагт МАН-аас нэр дэвшин өрсөлдөж байгаа Л.Мөнхбаатарын ухуулагч нар гар утасны нэгж тараасныг аймгийн Цагдаагийн газар шалгаж эхэлсэн. Бүх аймгийн төлөөллийг байршуулж, 1898 машинд хяналтын тооллого хийсэн. УИХ-ын сонгуулийн 67 дугаар тойрогт хариуцаагүй нэг нөхрөөс болж, будилаан гарсныг эс тооцвол 1897 машин үнэн зөв тоолж байна гэдгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан. Гэтэл санал тоолох машин нь Ардчилсан намын талд байгаа гэсэн цуу яриа гаргаж байгааг эрс эсэргүүцэж байна.

### 17:00 цаг

Нийслэлийн Сонгуулийн хорооноос сонгуулийн санал хураалтын ирцийн мэдээг 17:00 цагийн байдлаар танилцууллаа. Нийслэлийн есөн дүүргийн 397 санал авах байранд 3966 төрийн албан хаагч сонгуулийн ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 17:00 цагийн байдлаар нийслэлийн нийт сонгогчдын 48.0 хувь нь саналаа өгчээ.

### 18:00 цаг

Сонгуулийн ерөнхий хорооноос УИХ-ын сонгуулийн явцын талаар 18:00 явцыг мэдээллийг өглөө. СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Аймгийн хэмжээнд 61.5, нийслэлийн хэмжээнд 47.0 хувьтай байна. Харин 17:00 цагийн байдлаар улсын хэмжээнд 2016 оны

сонгуулийн санал хураалт 55.0 хувьтай явагдаж байна” хэмээсэн юм. Энэ үеэр зарим санал хураах байруудад саналын хуудас дутсан талаар мэдээлэл хуралдаж, аймаг сумдын сонгуулийн хороодод тогтоол гарган хүргүүлсэн гэдгийг дуулгасан юм. Түүнчлэн “Нэр бүхий гурван нэр дэвшигчийг жагсаалтаас хасах хүсэлт, гомдол Сонгуулийн ерөнхий хороонд ирсэн. Гурвууланг нь өнөөдрийн хурлаар авч хэлэлцэж, шийдвэрээ гаргасан. Нэгдүгээрт, 28 дугаар тойрогт МАХН-аас нэр дэвшигч М.Оюунсайхан сонгуулийн сурталчилгаага хийхдээ сонгуулийн хуулийг зөрчсөн гэж шүүхээс тогтоосон. Өөрөө давж заалдахгүй гэдгээ илэрхийлж, торгуулийн мөнгөө төлсөн гэдгээ мэдэгдсэн байгаа. Тиймээс СЕХ М.Оюунсайханыг нэр дэвшигчийн жагсаалтаас хасах шийдвэрийг гаргасан. Хоёрдугаарт, МАН-аас 14 дүгээр тойрогт нэр дэвшигч Х.Болорчулууны талаар сурталчилгааны үеэр самбар байрлуулах ёсгүй газарт самбар байрлуулсан гэсэн гомдол ирсэн. Улмаар Дорнод аймгийн сум дундын эрүүгийн анхан шатны шүүхийн зургадугаар сарын 23-ны өдрийн шийдвэрээр тогтоогдсон байсан. Шүүхийн шийдвэр хуулийн хугацаанд хүчин төгөлдөр болоогүй тул нэр дэвшигчийн зүгээс давж заалдана гэдгээ илэрхийлсэн. Тиймээс энэ асуудлыг хойшлуулсан байгаа. Гуравдугаарт, 49 дүгээр тойрогт МАН-аас нэр дэвшигч Д.Оюунхоролын туслах Н.Энхзаяа нь сонгуулийн тухай хуулийн 70 дахь заалтыг зөрчиж мөнгө тараахыг хориглох заалтыг зөрчсөн. Энэ нь Баянзүрх дүүргийн шүүхийн зургадугаар сарын 24-ний өдрийн шийдвэрээр тогтоогдсон. Д.Оюунхоролын туслах Н.Энхзаяагаас СЕХ-нд хүсэлт ирүүлсэн байгаа. Шүүхийн шийдвэрээр гар дээрээ аваагүй, давж заалдана гэсэн гомдол ирүүлсэн. Тиймээс энэ асуудлыг хойшлуулсан” гэлээ.

### 19:30 цаг

Ардчилсан намын ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр хоёр дахь удаагийн хэвлэлийн бага хурлаа хийлээ. Тэрбээр “Ардчилсан намын сонгуулийн штаб УИХ-ын сонгуулийн 49 дүгээр тойрогтой холбоотой гүтгэлтийн чанартай мэдээлэл хийлээ” гэж МАН-аас үйлдсэн. Гэвч Сонгуулийн ерөнхий хорооноос “УИХ-ын сонгуулийн 49 дүгээр тойрогт нэр дэвшигч Д.Оюунхоролын шадар туслах Н.Энхзаяа нь хууль зөрчсөнийг Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх тогтоосон. Шүүхийн шийдвэрийг дахин давж заалдах байгаа талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга хэллээ. Энэ бол шүүхийн шатандаа давж заалдаад явж байгаа хэрэг гэдэг нь нотлогдлоо. Бид гүтгээгүй нь батлагдлаа. Орон нутагт элдэв булхай гарсаар байгаа талаархи мэдээллийг Ардчилсан намын сонгуулийн төв штабт ирүүлсээр байна. УИХ-ын сонгуулийн 37 дугаар тойрог буюу Хөвсгөл аймагт МАН-аас нэр дэвшин өрсөлдөж байгаа Л.Мөнхбаатарын ухуулагч нар гар утасны нэгж тараасныг аймгийн Цагдаагийн газар шалгаж эхэлсэн. Бүх аймгийн төлөөллийг байршуулж, 1898 машинд хяналтын тооллого хийсэн. УИХ-ын сонгуулийн 67 дугаар тойрогт хариуцаагүй нэг нөхрөөс болж, будилаан гарсныг эс тооцвол 1897 машин үнэн зөв тоолж байна гэдгийг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан. Гэтэл санал тоолох машин нь Ардчилсан намын талд байгаа гэсэн цуу яриа гаргаж байгааг эрс эсэргүүцэж байна.

Үргэлжлэл нь IV нүүрт



**МОНГОЛЫН МЭДЭЭ**

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **НАЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

**Э.САЙНЗАЯА 99197866**

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

# ҮЗЭЛ БОДОЛ

## ЭРДЭНЭТИЙН 49 хувийн эргэн тойронд...

Дугаарын 60 мөр

Залуучууд сайн байлаа

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Ч.Сайханбилэг: Эрдэнэт үйлдвэр монголчуудын мэдэлд 100 хувь шилжлээ



-Ерөнхий сайд Ч.Сайханбилэг төгсгөлөөр чөлөөт цагааг 18.30 цагийн үед шуурхай хэвлэлийн хурал зарласан юм. Тэрбээр,

“Монгол Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийг 100 хувь Монгол Улсын мэдэлд шилжиж байгааг зарлах гэсэн юм. ОХУ-ын “Ростех” компанийн эзэмшиж байсан Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Монголын хувийн компани эзэмшихээр боллоо. Монголын компани гэдэг нь ХХБ-ны төлөөний компани болох “Монголын ээс” компани юм. Ингээд Эрдэнэт үйлдвэр манай улсын хуулиар зохицуулагддаг Монгол Улсын үндэсний аж ахуйн нэгж болж хувирах юм. Мөн тус үйлдвэрийн ногдол ашиг 100 хувь Монгол Улсад үлдэх болж байна. Нэгдүгээрт, Эрдэнэт үйлдвэрийг дагасан бүх барилга байгууламж Монгол

Улсад дагаж шилжиж ирнэ. Монгол Оросын хамтарсан “Монросветмет” компани энэ жишгээр 100 хувь Монгол Улсын аж ахуйн нэгж болж байгаа. Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Дансыг хаасан, тамга тэмдэг хураасан зүйл байхгүй. Хоёрдугаарт, зургаадугаар сарын 30-наас эхлэн хоёр тал албан ёсоор байр сууриа илэрхийлж мэдэгдүүдээ гаргаж эхэлнэ. Гуравдугаарт, энэ асуудлыг Оросын талын хамгийн өндөр төвшинд шийдвэрлэсэн гэдгийг хэлэхийг хүсч байна. Дөрөвдүгээрт, “Ростех” компани зөвхөн энэ хэлбэрээр хэлэлцээрийг хийнэ гэдгээ албан

ёсоор илэрхийлсэн баримт энд байгаа. Энд Монголын Засгийн газар болон аль нэг улсын Засгийн газар аль нэг гуравдагч этгээдэд 49 хувиа зарахгүй. Тавдугаарт, хэн нэг гуравдагч этгээдэнэхэлэлцээрт оролцохыг хориглосон гэдгийг дахин хариуцлагатайгаар хэлэхийг хүсч байна. Зургаадугаарт, хэрвээ Монгол Улсын компани худалдан авсан 49 хувиа зарах тохиолдолд зөвхөн Монгол Улсын Засгийн газарт эхний ээлжинд зарна. Долдугаарт, энэ хэлэлцээр дуусахад Монгол Улсын Засгийн газрын зүгээс энэ асуудлыг УИХ-д албан ёсоор оруулж танилцуулах болно” гэв.

Өмнө нь залуучууд гэртээ хэвтчихээд, дараа нь улс орон тэглээ, ингэлээ. Залуучууд бидэнд чөлөөт цагаа өнгөрөөх газар алга. Хөгжихгүй байна гэх мэтээр шүүмжлэх л ажил хийдэг байсан. Хатуухан хэлэхэд шүү дээ. Тэгвэл энэ удаад залуучууд дөрвөн жилд нэг удаа эдэлдэг сонгох, төлөөллөөрөө дамжуулж төр барих эрхээ маш сайн эдэлж чадлаа. Тэр дундаа хөдөө, орон нутгийнхан нийслэлийнхнээс илүү ухамсартай байна. Увс аймагт гэхэд 17:00 цагийн үед сонгогчдын 80 гаруй хувь нь саналаа өгсөн гэсэн мэдээ гарч байсан. Энэ бол амжилт. Залуучууд бид олноороо саналаа өгвөл бидний сонгосон хүмүүсээс бүрдсэн УИХ, цаашлаад Засгийн газар тогтоно. Хэрвээ өгөөгүй бол ахмадуудын саналаа өгсөн хүмүүсээс бүрэлдсэн төр л тогтоно шүү дээ. Өвөө, эмээ, ээж, аавараа гутал авахуулчихаад, голоод сууж байвал юу болох билээ, тийм биз дээ. Үүнтэй адил өөрсдөө саналаа өгөхгүй байж, ахмадуудын санал өгч бүрдүүлсэн төрийг муулж суух эрх бидэнд байхгүй. Энэ мэтийг өнөө жил залуучууд нэлээд ухамсарлаж, ойлгож. Тиймдээ ч саналаа идэвхтэй өглөө гэж ойлгож байна. Залуу та МАНдуулаа уу, ахиулАН ажил хийлгэхийг хүснэ үү, бие даагчдыг дугуйлаа уу, эсвэл бүр гурав, дөрөвдөгч хүчнийг дэмжинэ үү, хамаагүй. Хамгийн гол нь өөрийнхөө итгэл үнэмшлээр, төрд төлөөлөх ёстой гэж бодсон хүнээ ямар нэгэн нөлөөлөлийгээр сонголтлоо хийж л байвал сайн хэрэг шүү дээ. Ядаж л өөр сонголт хийнэ. Сүүлийн хэдэн жил залуучууд бид өөрчлөх цаг болсон хэмээн ярьж, бухимдаж байгаа. Энэ жилийн сонгуулиар залуучууд идэвхтэй оролдож байгаа болохоор өөрчлөлт ирж байгаа гэж ойлгож болохоор байна. Дээрээс нь дахин санал хураалт явуулж, улс орны мөнгө үрэхгүй шүү дээ. Ерөөсөө монголчуудыг залуу улс гэдэг.

МАН: Ерөнхий сайд 49 хувийг хувьдаа завших гэж байна



“Эрдэнэт” үйлдвэр Монгол Улсын мэдэлд 100 хувь шилжсэнтэй холбогдуулан Ерөнхий сайд мэдэгдэл хийсний дараа улс төрийн намууд ээлж дараалан мэдэгдэл гаргаж эхэлсэн юм. Тодруулбал, МАН-ын зүгээс албан ёсны мэдэгдэл гаргасан хэмээн хэвлэлийн хурал зарлав. Тус мэдэгдэлд

“Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хэдхэн мөчийн өмнө хэвлэлийн хурал хийж, “Эрдэнэт” үйлдвэрийн Оросын талын 49 хувийг Худалдаа Хөгжлийн Банк түүний төлөөний компани болох “Монголын Ээс” компани хувьчилж авсан тухай мэдээллээ. Маргааш /өчигдөр/ УИХ-ын сонгуулийн

санал хураалт явагдах гэж байгаа эгзэгтэй мөчид АН-ын удирдлага, тухайлбал Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг хувьдаа завших луйвар хийж байгааг Монгол Ардын Нам эрс эсэргүүцэж байна. 49 хувийг Монгол Улсын иргэдэд ногдол ашиг хэлбэрээр хувь

болгон эзэмшүүлэх ёстой. Мөн УИХ, Засгийн газарт огт танилцуулалгүйгээр гадаадын оффшор компанид сонгон шалгаруулалтгүйгээр өгсөн асуудлыг Үндсэн Хуулийн Цэцэд өгнө. Энэ асуудлаар УИХ-аас ажлын хэсэг байгуулан шалгана” гэжээ.

итгэл үнэмшлээр, төрд төлөөлөх ёстой гэж бодсон хүнээ ямар нэгэн нөлөөлөлийгээр сонголтлоо хийж л байвал сайн хэрэг шүү дээ. Ядаж л өөр сонголт хийнэ. Сүүлийн хэдэн жил залуучууд бид өөрчлөх цаг болсон хэмээн ярьж, бухимдаж байгаа. Энэ жилийн сонгуулиар залуучууд идэвхтэй оролдож байгаа болохоор өөрчлөлт ирж байгаа гэж ойлгож болохоор байна. Дээрээс нь дахин санал хураалт явуулж, улс орны мөнгө үрэхгүй шүү дээ. Ерөөсөө монголчуудыг залуу улс гэдэг.

Н.Энхбаяр: Оросын тал хувиа зарах бол манай УИХ-аар хэлэлцүүлэх ёстой



-Мөн энэ өдөр МАХН-ын дарга Н.Энхбаяр, Шадар сайд Ц.Оюунбаатар, Барилга хот байгуулалтын сайд З.Баянсалэнгэ нар шуурхай хэвлэлийн хурал зарласан юм. МАХН-ын зүгээс мөн л 49 хувийг Монгол Улсын мэдэлд өгч буй асуудлыг эсэргүүцэж буйгаа илэрхийлэв. МАХН-ын дарга Н.Энхбаяр “Сонгуульд бүгдээрээ анхаарал хандуулсан энэ цаг үед Засгийн газар УИХ-д танилцуулахгүйгээр хамгийн

нэр хүндтэй, чухал асуудлыг хувийн компанид зарна гэдгээ сайн мэдээ гэж зарлаж байна. Аль нэг тал нь өөрийнхөө хувийг зарах гэж байгаа бол нөгөө талынхаа Засгийн газарт мэдэгддэг. Нөгөө талын Засгийн газар нь авах эсэхээ албан ёсоор ил тод нээлттэй хэлэлцэж шийдвэрлэдэг. Тэр утгаар нь аваад үзэхэд үнэхээр Оросын тал өөрийнхөө хувийг зарахаар болсон бол манай Засгийн газар УИХ-д оруулж

хэлэлцүүлэх ёстой. Нуугаад байх юм ерөөсөө байхгүй. УИХ Засгийн газарт ав гэсэн үүрэг даалгавар өгөх ёстой. Эрдэнэт бол монголын ард түмний бахархал, үндэсний аюулгүй байдлын бас нэг чухал хүчин зүйл. Бид Оросын 49 хувийг зөвхөн Монгол Улсын Засгийн газар авах ёстой гэсэн байр суурийг барьж байгаа. Энэ асуудлыг яаралтай шийдвэрлэхийг УИХ, УИХ-ын дарга З.Энхболдоос шаардаж

байгаа. З.Энхболд дарга ээлжит бус чуулган хуралдуулахад шийдвэр гаргах эрхтэй учраас шаардлага тавьж байна. Өнөөдөр ээлжит бус чуулганыг хуралдуулъя. Эрдэнэт сонгууль далимдуулж алга болж болохгүй. Эрдэнэтийг авч байгаа нөхдүүдийг харахад 2.2 хувь буюу 49 хувь нь Монголд бүртгэлтэй, бусад 51 хувь нь гадаадын нөхөд авч байгаа мэдээлэл бий. Тиймээс үүнийг зогсоох ёстой” гэв.

З.Энхболд: Эрдэнэтийг улстөржүүлж болохгүй



-УИХ-ын дарга, АН-ын дарга З.Энхболд Эрдэнэт үйлдвэр 100 хувь Монгол Улсын мэдэлд шилжиж буй асуудлын талаар байр сууриа өчигдөр сонгуульд санал өгөх үедээ илэрхийлэв. Тэрбээр, сэтгүүлчдийн асуусан асуултад хариулт өгөхдөө “Манай улсын олон жилийн бодлого бол Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг худалдан авах саналыг үе уеийн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар Оросын талд тавьдаг байсан. Ташкентын дээд

хэмжээний уулзалтын үеэр энэ асуудал шийдэгдэж, Оросын талаас албан ёсоор зарах санал ирсэн. Ямар ч байсан Эрдэнэт үйлдвэр Монголынх болох гэж байна. Хуулийнхаа дагуу УИХ-аар хэлэлцэгдэх ёстой. Үүнийг сонгуулийн улс төр болгож байгаа нь туйлын харамсалтай. Энд ямар ч улс төр байхгүй, Монгол Улсын баялаг Монголын мэдэлд ирж байгаад дургүйцэж байгаа зарим нэг хүмүүсийг огт ойлгохгүй байна. Гэрээний

дагуу Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Монголын талд зарах ёстой, өөр ямар нэгэн талд санал тавих, зарах эрхгүй юм. Энэ дагуу л манайд санал тавьсан, тэр дагуу бүх ажил явагдана. МАН, МАХН болон хууль бус шахааны бизнесийнх нь эрх ашиг хөндөгдөж буй зарим бизнесийн байгууллагууд цуу яриагаа зогсоох хэрэгтэй. Монголын хөрөнгө Монголынх болж байна. Хэзээ нэгэн цагт Рио-Тинто өртгөө нөхсөнийхөө

дараа Монголын талд зарах санал тавих байх. Тэр үед бас л өнөөдрийнх шиг хий хоосон улс төр хийж болохгүй. 1990 онд Улаанбаатар төмөр замыг худалдах саналыг Оросын талаас тавьсан, бас ингэж улстөржиж байгаад аваагүй байдаг юм. Энэ бол сургамж Битгий улстөрж, Монголын баялаг Монголд эргэн ирлээ, энэ талаар ард иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах ёстой” хэмээлээ.

Худалдаа хөгжлийн банк мэдэгдэл гаргажээ




-49 хувийг худалдаж авсан Худалдаа хөгжлийн банкнаас мэдэгдэл гаргажээ. Тодруулбал, “МАН, МАХН-ын удирдлагын зүгээс ОХУ-ын “Ростех” компанийн эзэмшдэг “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг ХХБ-аар дамжуулан хятадууд авлаа гэсэн худал мэдээлэл тарааж

байна. Иймд доорх тайлбарыг нийт монголчууддаа хүргэхээр шийдлээ. Манай ХХБ-ны 95 хувийг монголчууд эзэмшдэг. “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг эзэмшихээр болсон “Монгол ээс” компанийг 100 хувь монголчууд эзэмшиж байна. ОХУ-ын “Ростех” компани

“Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг зарах саналаа ирүүлсэн учраас гэрээ хэлцэлд орсон билээ. Худалдаа Хөгжлийн Банкныг санхүүгийн үйлчилгээ үзүүлж чадна гэдэг утгаар нь сонгосон болно. Монголчууд “Эрдэнэт” үйлдвэрээ 100 хувь эзэмших болсон мэдээг сонгуультай

холбогдуулан улстөржүүлж буй нам, эвслүүдийг уяагүй үйлдлээ таслан зогсоохыг шаардаж байна. Монголчуудын мэдэлд “Эрдэнэт” үйлдвэр шилжин ирснээр улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэж байна” гэв.

Газеты.ru: 49 хувийн хувьцаа 200 сая ам.доллар хүрнэ



-Монголын “саалийн үнээ” гэгдэх Эрдэнэт үйлдвэрийн 49 хувийг Монголын талд өгсөн асуудлаар ОХУ-ын хэвлэлүүд байр сууриа илэрхийлж эхэллээ. Тухайлбал, өчигдөр ОХУ-ын “газеты.ru” сайтад “ОХУ-ын Засгийн газар өөрийн эзэмшил 49 хувийг худалдсан тухай “Ростех” компанийн хөрөнгө оруулалтын холдинг болох “РТ-

Развитие бизнеса” мэдэгдлээ. Харин худалдан авагч тал нь Монгол ажээ. Монголын тал эхэндээ “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг 0.7 сая ам.доллараар үнэлж байсан ч, эцэстээ 0.5 сая ам.доллараар худалдан авсан гэсэн мэдээлэл байгаа юм. “Ростех” бизнес хөгжлийн агентлаг “Энэ нь ОХУ, Монголын зах зээлийн нөхцөлд

харилцан ашигтай гэрээ болсон. Хувьцааны 49 хувийг худалдах багцыг эд хөрөнгийн чанар, түүний хөгжлийн боломжийг харгалзан зах зээлийн хамгийн боломжийн үнэлгээгээр үнэлсэн. Гэрээний үнийн нөхцлийг олон улсын аудит үнэлгээний байгууллагууд, зөвлөхүүдийг оролцуулан тохирсон” хэмээв. Зарим

эх сурвалжуудын мэдээлж буйгаар Ростех бизнес хөгжлийн агентлаг компанийн эзэмшил хувьцаагаа дэлхийн зах зээлд худалдаасан бол 150-200 сая ам.долларын үнэ хүрэх боломжтой байжээ. Мөн Оросын Interfax.ru сайтад “Ростех” Монголд хувиа зарснаар 500 сая ам.доллар авч магадгүй гэж бичжээ.

49 хувийн талаар эдийн засагчид юу хэлэв



-Өмнө хэлсэнчлэн Эрдэнэт үйлдвэр Монголын мэдэлд ирсэн нь улс төрийн сонгуультай давхцсан учраас улс төрийн намууд олон янзын тайлбар өгч байв. Тэгвэл харьцангуй улстөржилт багатай, мэргэжлийн талаас судалгаатай дүгнэлт хэлэх

учиртай эдийн засагчид ч энэ талаар хоёр хуваагджээ. Тухайлбал, эдийн засагч Д.Жаргалсайхан “Эрдэнэтийг нууцаар авсныг шүүмжлэх нь мэдээж. Одоо явал хамгийн ухаалаг байдлаар дараагийн алхмаа хийх вэ гэдгээ бод. 40 хувиа Засгийн газарт зараад,

Худалдаа хөгжлийн банк нэрээ цэвэрлэхээ бод” хэмээн байр сууриа илэрхийлсэн бол төмөр замын инженер Ц.Бат “Оросууд эдийн засгийн хоригт орж мөнгө нь дундарч байгаа энэ үеийг тааруулж Эрдэнэтээ салгаж авна гэдэг чинь бидний хувьд тэнгэрийн

умдаг шүү. Засгийн газар ХХБ-тай Оросоос авсан Эрдэнэтийн 49 хувийг зарах бол Засгийн газарт эхэлж санал тавих ёстой. Гэрээ байгуулаад л бүх асуудал Монголд ашигтайгаар шийдэгдэнэ” хэмээн байр сууриа илэрхийлэв.

Хүн амын бараг 70 хувь нь залуус байгаа. Залуучууд бид дандаа шинэ, сайхан бүхнийг хүсдэг биз дээ. Хэрвээ тэр шинэ, сайхан бүхнээ хүсч байвал ядаж л сонгуульдаа идэвхтэй оролцох ёстой байсан. Ямар ч байсан өнгөрсөн 2012 оны сонгуулийг бодвол идэвх сайтай оролцлоо. Залуучуудын ухамсар сэргэж байна. Мэдлэг мэдээлэлтэй ч болж. Энэ янзаараа байвал бид 2020 оны сонгуулиар 100 хувь саналаа өгөөд, зөв хүнээ сонгоод явах юм байна. Сайн цагийг залуус бид л авчирна. Залуус бидний сонгосон төлөөлөл арай өөрөөр ажиглах байх гэдэгт итгэж байна. Сонгуульдаа идэвхтэй оролцсон залуучууддаа баярлалаа. Залуус бид л энэ улс орны юм бүхэнд идэвхтэй оролдож байж сайн, сайхан, өөрсдийн хүссэн ирээдүйг авчирна шүү дээ.

## УЛС ТӨР

СОНГУУЛЬ 2016

## МАН ҮНЭМЛЭХҮЙ ЯЛАЛТ БАЙГУУЛЛАА

Үргэлжлэл.  
Түрүүч нь II нүүрт

Нэр дэвшигч Г.Баярсайханыг сүүлийн 14 хоногийн турш нүцгэн шалдан, эвлүүлэг хийж доромжилсон. Өнөөдрөөс эхлэн мөнгө тараасан гэж ор үндэсгүйгээр гүжирдээ. Төв аймагт нэр дэвшин өрсөлдөж байгаа А.Сүхбат намынхаа мөрийн хөтөлбөрт огт тусгаагүй асуудлаар амлалт өгснийг хууль хяналтын байгууллагаар шийдүүлэх гэсэн ч одоог болтол шийдэгдээгүй. Сонгинохайрхан дүүрэг, Төв, Хөвсгөл аймгуудад өгсөн гомдолд цагдаагийн байгууллага хөшүүн хойрго хандаж байна. Өрсөлдөгч намын зүгээс санал авах байрны өмнө зохиомол дугаарлал үүсгэх, элдэв явуулга хийж байгаа талаар мэдээлэл ирж байна. Ардчилсан намаас 21.00 цагаас мөнгө тараана гэсэн явган яриаг зориудаар тарааж байна. Ардчилсан нам мөнгө тараахгүй, сонгуульд шударгаар өрсөлдөх болно. Сонгогчдыг сонгуульдаа идэвхитэй оролцохыг уриалж байна” гэлээ.

## 20:00 цаг

Нийслэлийн Сонгуулийн хорооноос сонгуулийн санал хураалтын ирцийн мэдээг 20:00 цагийн байдлаар танилцууллаа. Нийслэлийн нийт сонгогчдын 517 149 буюу 61.3 хувь нь саналаа өгчээ. Санал хураалт хэвийн үргэлжилж байгаа талаар дуулгасан. Дараагийн мэдээллийг шөнийн 01:00 цагт хийнэ гэдгээ мэдэгдэв.

## 20:30 цаг

МАН-ын Сонгуулийн штабын дарга, УИХ-ын гишүүн Су.Батболд тэргүүтэй албан хүмүүс дахин мэдээлэл хийлээ. Тэрбээр “АН-ынхан “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг хувийн компанид хувьчилсан шийдвэрийг “Монголын ард түмэнд өмчийг нь буцааж өглөө. Энэ нь зөв зүйтэй шийдвэр болсон гэх мэдээллийг олон удаа давтан гаргаж байна. Тийм учраас энэ асуудал дээр МАН-аас дахин байр сууриа илэрхийлэхээс өөр аргагүй боллоо. МАН “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг хувьчилсан булхайтай явдалтай холбоотойгоор Үндсэн хуулийн цэцэд хандана. Энэ шийдвэрийг зөв талд нь гаргахын төлөө шийдвэртэй алхам хийнэ. Хоёрдугаарт, СЕХ-ны хариуцлагагүй байдлаас болж сонгогчид саналаа өгч чадахгүй байдалд хүрээд байна. Тухайлбал, Архангай, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийн сонгогчид санал хураах байранд очоод, 1-2 цаг хүлээж байгаа. Цаашлаад санал өгөх хуудас дууссан гэх шалтгаанаар саналыг нь өгүүлэхгүй байгаа талаар гомдол ирж байна. Энэ бол сонгогчийн эрхийг ноцтой зөрчсөн үйлдэл гэж МАН-ын зүгээс үзэж байгаагаа илэрхийлэв” гэлээ. Мөн тэрбээр “СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн мэдээлэл хийхдээ дутсан саналын хуудсыг хувиулж санал өгүүлэх, явуулын хайрцагар санал авах журам баталлаа гэсэн. Энэ бол сонгуулийн хуулийг ноцтой зөрчиж байгаа зүйл. Үүнээс үүдэн бий болсон үр дагаварыг СЕХ хүлээнэ гэдгийг МАН-ын сонгуулийн штабаас хариуцлагатайгаар мэдэгдэж байна” хэмээн ярилаа. Энэ үеэр МАН-ын Сонгуулийн штабын хэсгийн дарга Д.Мөрөн “Өнөөдөр мөн О.Амгаланбаатарын төлөө саналаа өгөөч гэж 10 мянган төгрөг иргэдэд тараасныг цагдаагийн байгууллага шалгаж байна. Баянхонгор аймагт нэр дэвшигч Д.Ганбатын туслах Цэндсүрэн мөнгө тараасан үйлдлээрээ хууль зөрчсөн байх магадлалтай гэж үзсэн учраас шүүхэд илжүүлсэн. Сонгуулийн сурталчилгаа дууссан, гэтэл нэр дэвшигч З.Баянсалзэнг, О.Цолмон нар бие даасан нэвтрүүлэгт оролцсон. “Эрдэнэт”-ийн талаар шууд нэвтрүүлэгт орсон. Ийм нэвтрүүлэгт орох нь хууль зөрчсөн үйлдэл. УИХ-ын дарга З.Энхболд саналаа өгөх үеэрээ сурталчилгаа хийлээ. “Эрдэнэт”-ийн асуудлаар Нэр дэвшигч Д.Оюунхорол, Ч.Хүрэлбаатар нар гүтгэсэн гэдэг асуудлаар цагдаагийн байгууллагад хандсан” гэлээ.

## 21:00 цаг

Архангай аймгийн АН-аас мэдэгдэл гаргав. Тодруулбал, Энэ сарын 28-ны өдрөөс 29-нд шилжих шөнө “АН-ынхан Архангай аймагт архи тарааж байгаад баригдлаа” гэсэн нэртэй бичлэг цахим ертөнцөөр цацагдсан. Гэтэл энэхүү бичлэгт ямар ч архи тараасан, сонгуулийн сурталчилгаа хийсэн үйлдэл байхгүй бөгөөд Сонгуулийн тухай хуульд заасны дагуу энэ сарын 27-ны өдрийн 00:00 цаг гэхэд албан ёсоор сонгуулийн сурталчилгааг зогсоосон аж. Энэ тухай Их Тамир сумын АН-ын сонгуулийн штабын ажилтан Баярсайхан мэдээлэл хийлээ. Тэрбээр зургадугаар сарын 27-ны өдөр “Арав орчим жийп машинд ачсан

их хэмжээний мөнгийг МАН-аас тараах гэж байна” гэсэн мэдээлэл авчээ. Энэ мэдээллийн дагуу АН-ын сонгуулийн штабаас эргүүл хийж шалгасан байна. Эргүүлийн явцад 27-ны өдрийн 23 цагийн орчим ямар ч улсын дугааргүй гурван машин Их Тамир сумын Хаан банкны захирлын үүдэнд зогсч байсан. Энэ нь сэжигтэй санагдсан тул АН-ын сонгуулийн штабын ажилчид бичлэг хийн баримтжуулсан байна. Тэдгээр хүмүүсийн дотор нэр дэвшигч Г.Тэмүүлэн байсан аж. Үүний дараа 28-ны орой дахин эргүүл хийсэн байна. АН-ын сонгуулийн штабын эргүүлийн бүрэлдэхүүн суудлын жижиг машинтай байсан учир том машиныг гүйцэхэд хэцүү байжээ. Ингээд Тариат сумаас Архангай аймгийн төв хүртэл өөрийн намын нэг жолоочийг дайчилсан байна. Эргүүл хийх явцад АН-ын сонгуулийн штабын машиныг арав орчим машин бүчигж зогсоогоод дайралт хийсэн байна. Дайралт хийсэн хүмүүсийн дунд согтуу хүмүүс ч олон байжээ. Мөн дайрч давшинсан хүмүүсийн дунд өөрийгөө цагдаа гэж танилцуулсан н.Отгонбаатар гэж хүн байсан байна. Тэрбээр хотод амьдардаг, Их тамир суманд сурталчилгааны ажлаар ажиллаж байгаа нэгэн аж. н.Отгонбаатар нь бүдүүлэг ашигчид АН-ын ажилчдаас бичиг баримтыг нь шаардан, машиныг нь цонхыг балбаж байжээ. АН-ын сонгуулийн ажилчид машиныхаа хаалгыг онгойлгож өгөөгүй бөгөөд цагдаа дуудан асуудлыг шийдсэн. Цагдаа ирэн АН-ын ажилчид руу халдсан машинд нэгжлэг хийхэд хоёр авдар архи гарч ирсэн байна. АН-ын зүгээс архи тараасан явдал огт гараагүй бөгөөд хэрэв ажилтан Баярсайхан архи тараасан нь нотлогдвол хуулийн хариуцлага хүлээхэд бэлэн байна гэв.

## 21:40 цаг

МАН-ын Сонгуулийн штабын дарга, УИХ-ын гишүүн Су.Батболд гурав дахь удаагаа хэвлэлийн бага хурал хийлээ. Тэрбээр энэ удаад МАН-ын ажиглагчдыг машинаар мөргөж гэмтээсэн талаар мэдээлсэн юм. Тодруулбал, УИХ-ын 64 дүгээр тойрогт нэр дэвшигч Г.Баярсайханы сонгуулийн штабын ажилтнууд тус тойрогт нэр дэвшигч М.Оюунчимэгийн сонгуулийн штабд ажиллаж байсан ажлын хэсгийн хоёр хүнийг машинаар дайрсан хэрэг гарчээ. Энэ талаар “Иргэд сонгогчид сонгуульдаа идэвхитэй оролцоо. Бүх тойргийн хэсгийн хороонд ирц өндөр байна. Гэхдээ штабын маань хоёр хүн машинд дайруулан гэмтэж, эмнэлэгт хүргэгдэнд сэтгэл дундуур байна” хэмээсэн юм.

## 22:00 цаг

УИХ болон аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийг сонгох сонгууль хуулийн дагуу 22:00 цагт санал хураалт дууслаа. Яг одоо УИХ-ын сонгуульд урьдчилсан байдлаар сонгогдсон нэр дэвшигчдийн нэрийг СЕХ-ноос зарлаж байна.

## 23:40 цаг

УИХ-ын сонгууль болон аймаг, нийслэл ИТХ-ын сонгуулийн санал хураалт өнөөдөр болж, амжилттай явагдаж өндөрлөлөө. Сонгуулийн тухай хуульд заасан дагуу санал хураалтын ажиллагаа хэсгийн хороодууд дээр өглөөний 07:00-22:00 цагийн хооронд явагдаж дууссан юм. СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн мэдээлэл хийж, урьдчилсан байдлаар УИХ-ын 2016 оны сонгуульд 76 тойрогт ялалт байгуулсан нэр дэвшигчдийг танилцууллаа. Сонгуулийн урьдчилсан дүнгээр МАН үнэмлэхүй ялалт байгуулж, сонгогчид АН-д итгэл алдарсан нь харагдлаа.

## 00:20 цаг

СЕХ мэдээлэл хийж, сонгуулийн урьдчилсан дүнг мэдээллээ. Архангай аймгийн тойрог болон зарим нэг аймагас бусад хэсгийн хороодын саналын нэгдсэн дүн урьдчилсан байдлаар гараад байгаа юм. Сонгуулийн нэгдсэн дүн удахгүй гарах бөгөөд өнөөдөр 09:00 цагт мэдээлэл хийхээр боллоо.

## 00:50 цаг



МАН мэдээлэл хийлээ. Тус намын дарга Н.Энхболд сэтгүүлчдэд хандан мэдээлэл хийхдээ “Монголын ард түмэн минь сонгуульдаа идэвхтэй оролцож, саналаа өгснөөр бидэнд их итгэл үзүүлээ. УИХ-ын сонгуульд урьдчилсан байдлаар 63 суудал авлаа гэсэн мэдээллийг ирүүлээ. Мөн нийслэлд олонхи болсон гэх мэдээлэл бидэнд ирээд байна. Та бүхэндээ бидэнд итгэл үзүүлсэнд баярлалаа” хэмээсэн юм. Ийнхүү сонгуулийн үр дүн төсөөлж байснаас өөрөөр эргэлээ.



Гэрэл зургийг Г.АРТУУЖИHN

Аймаг, нийслэл	Тойрог	Сонгогчийн тоо	13:00 цагийн байдлаар	18:00 цагийн байдлаар	22:00 цагийн байдлаар	Ялалт байгуулсан	
Архангай аймаг	1-р тойрог	20448	22.9	71.1		МАН Г.ТЭМҮҮЛЭН	
	2-р тойрог	19057	26.6	59.1		МАН Ё.БААТАРБИЛЭГ	
	3-р тойрог	19626	26.1	69.4		МАН Ж.МӨНХБАТ	
Баян-Өлгий аймаг	4-р тойрог	19845	16.3	57.5	82.2	МАН Г.СОЛТАН	
	5-р тойрог	21379	18.4	68.2	76.7	8143	МАН Х.БАДЕЛХАН
	6-р тойрог	18471	18.6	64.9	81.8		АН Д.МУРАТ
Баянхонгор аймаг	7-р тойрог	17370	35.6	53.3	82.2		МАН Г.ЗАНДАНШАТАР
	8-р тойрог	18015	32.8	69.7	79.4		АН Н.ТҮВШИНБАЯР,
	9-р тойрог	18711	27.3	75.2	78.8		МАН Л.ЭЛДЭВ-ОЧИР
Булган аймаг	10-р тойрог	40268	23.6	59.2	75.4		МАН Ж.БАТ-ЭРДЭНЭ,
Говь-Алтай аймаг	11-р тойрог	35051	33	69.7	79.7		МАН Ш.РАДНААСЭД,
Говьсүмбэр аймаг	12-р тойрог	21125	32.3	63.5	77.3		МАН Г.МӨНХЦЭЦЭГ,
Дорноговь аймаг	13-р тойрог	31074	25.4	56.1	71.5		МАН Б.ДЭЛГЭРСАЙХАН
Дорнод аймаг	14-р тойрог	26289	32.7	55.1	73.4		МАН Х.БОЛОРЧУЛУУН
	15-р тойрог	24688	28.1	53	70.9		МАН Н.НОМТОЙБАЯР,
Дундговь аймаг	16-р тойрог	29473	26.1	64.1	75.5		АН Б.НАРАНХҮҮ
Завхан аймаг	17-р тойрог	23495	31.2	76.3	85.9		АН Я.САНЖМЯТАВ,
	18-р тойрог	21734	30.7	69.3	81.1		АН З.НАРАНТУЯА,
Өвөрхангай аймаг	19-р тойрог	25387	28.5	61.5	75.2		МАН Я.СОДБААТАР,
	20-р тойрог	20390	29.3	54.9	68.8		МАН Д.ТОГТОХСҮРЭН,
Өмнөговь аймаг	21-р тойрог	25292	30.2	67.8	79.9		МАН С.ЧИНЗОРИГ,
	22-р тойрог	20541	33.8	62.1	70.8		МАН Н.АМАРЗАЯА,
Сүхбаатар аймаг	23-р тойрог	19869	29	57.3	72.3		МАН Л.ЭНХБОЛД
	24-р тойрог	39595	32.6	67.1	72.8		МАН Ч.УЛААН,
Сэлэнгэ аймаг	25-р тойрог	24572	48	52.9	69.6	7616	МАН Н.ОЮУНДАРЬ,
	26-р тойрог	25126	22.6	54.3	69.4	7962	МАН Ж.ЭРДЭНЭБАТ,
	27-р тойрог	20399	38.5	61.5	75.2		АН Д.ЭРДЭНЭБАТ
Төв аймаг	28-р тойрог	19420	21.4	59.9	75.2		МАН М.ЭНХБОЛД,
	29-р тойрог	20579	23.5	58.9	73.1		МАН А.СҮХБАТ,
	30-р тойрог	22145	24.4	63.3	76.9		МАН Н.ЭНХБОЛД
Увс аймаг	31-р тойрог	16032	26.9	81.4			МАН Б.ЧОЙЖИЛСҮРЭН
	32-р тойрог	17097	27.8	69.2	83.4		МАН Ч.ЦЭРЭНБАТ
	33-р тойрог	15790	29	70	83.6		МАН Ч.ХҮРЭЛБААТАР
Ховд аймаг	34-р тойрог	14327	29.4	70.9	83.2		МАН Б.ОЧБАДРАХ
	35-р тойрог	16067	25.3	66.9	81		МАН С.БЯМБАЦОГТ
	36-р тойрог	20423	33.9	65.2	74		МАН О.БАТНАСАН
Хөвсгөл аймаг	37-р тойрог	25687	21.8	58.9	72.6		МАН Л.МӨНХБААТАР,
	38-р тойрог	31187	21.2	56.6	69.8		МАН Ц.ДАВААСҮРЭН,
	39-р тойрог	26242	23	61.7	74.8		МАН Л.ЭНХ-АМГАЛАН,
Хэнтий аймаг	40-р тойрог	15698	32.7	62.5	75.6		МАН Б.БАТ-ЭРДЭНЭ,
	41-р тойрог	14867	25.5	63.1	80.5		МАН Б.БАТ-ЭРДЭНЭ
	42-р тойрог	15713	27.7	60	75.3		МАН Д.ГАНТУЛГА,
Дархан-Уул аймаг	43-р тойрог	23064	24.6	49.9	70.5	6553	МАН Б.БАТТӨМӨР,
	44-р тойрог	21401	23.5	51.7	71.1	6716	МАН Б.ЖАВХЛАН
	45-р тойрог	22261	25.3	50.9	69.2		МАН Д.ХАЯНХЯРВАА,
Орхон аймаг	46-р тойрог	21255	28.4	53.8	68.1	5751	МАН О.СОДБИЛЭГ,
	47-р тойрог	21310	25.1	50.3	71.2	4222	МАХН О.БААСАНХҮҮ,
	48-р тойрог	21238	24.5	48.6	69.7	4725	МАН Д.ДАМБА-ОЧИР,
Баянзүрх дүүрэг	49-р тойрог	38384	12.7	43.7	60.9	7616	МАН Д.ОЮУНХОРОЛ,
	50-р тойрог	33477	17.3	51.4	66	11408	МАН Ж.ЭНХБАЯР,
	51-р тойрог	35800	17.1	41.4	61.1	8660	МАН Б.САРАНЧИМЭГ
	52-р тойрог	38999	17.1	44.3	65	8985	МАН Б.БАТЗОРИГ
	53-р тойрог	32117	19.2	46.8	65.1	8491	АН Ж.БАТЗАНДАН,
	54-р тойрог	40630	20.2	49	54.5	11029	Бие даагч С.ЖАВХЛАН
Хан-Уул дүүрэг	55-р тойрог	27875	19.4	51.6	73.9	6331	МАН Д.САРАНГЭРЭЛ,
	56-р тойрог	28776	18.3	51.4	78	9648	МАН Ц.НЯМДОРЖ
	57-р тойрог	26313	19	47.9	73.5	5296	АН Л.БОЛД
Сүхбаатар дүүрэг	58-р тойрог	23912	20.3	48.3	72.9		МАН Б.ЭНХ-АМГАЛАН
	59-р тойрог	26974	14	54.1	74.2	8043	МАН Д.ЦОГТБААТАР
	60-р тойрог	27697	16.4	48.1	71.7		МАН Ц.МӨНХ-ОРГИЛ
Багануур, Баганхангай дүүрэг	61-р тойрог	26119	14.3	42.2	68.6	7340	МАН С.БАТБОЛД
	62-р тойрог	33864	16.2	47.7	75.6		МАН Ц.ЦОГЗОЛМАА
Чингэлтэй дүүрэг	63-р тойрог	45312	17.1	48.8	74.7	12704	МАН Т.АЮУРСАЙХАН
	64-р тойрог	27610	15.8	42	70.4	6590	МАН М.ОЮУНЧИМЭГ
	65-р тойрог	27660	15.9	41.3	67.6	6058	МАН Ө.ЭНХТҮВШИН
Налайх дүүрэг	66-р тойрог	33971	15.6	40	65.8	6844	МАН Д.ГАНБОЛД
	67-р тойрог	38138	17.2	49.9	72.9	9268	МАН А.Ундраа
	68-р тойрог	34323	17.6	49.2	70.3	10614	МАН Ж.ГАНБААТАР
Баянгол дүүрэг	69-р тойрог	32828	19.1	48.9	70.9	7477	АН С.ЭРДЭНЭ,
	70-р тойрог	34578	27.9	53	73.8	7672	МАН Д.ЛҮНДЭЭЖАНЦАН
	71-р тойрог	35327	19.2	51.4	66.3	9241	МАН Ц.ГАРАМЖАВ
Сонгинохайрхан дүүрэг	72-р тойрог	30817	19.5	47.9	69	9486	МАН Н.УЧРАЛ
	73-р тойрог	27641	21.4	47.9	66.8	9577	МАН Д.СУМГЯАБАЗАР
	74-р тойрог	35420	17.8	43.5	64	8106	МАН Д.ТЭРБИШДАГВА
	75-р тойрог	38229	20.8	44.7	67.5	9673	МАН Б.УНДАРМАА
	76-р тойрог	37243	19.2	43	65.6		МАН Х.НЯМБААТАР

# СОНГУУЛЬ - 2016



Гэрэл зургийг Г.АРТУУЖИЙН



# ДЭЛХИЙ

## ЭЭЛЖИТ ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙГ ДЭЛХИЙ ИНГЭЖ ДҮГНЭЛЭЭ

Б.ДАВАА

Монголчууд бид хууль тогтоох байгууллага дахь өөрийн төлөөллөө сонгох Үндсэн хуульд заасан эрхээ эдэлж, сонголтоо хийлээ. Байгалийн асар их нөөц баялагтай, хоёр том гүрний дунд орших Ардчилсан Монгол Улсын парламентын сонгууль жилээс жилд дэлхий нийтийн анхаарлын төвд байдаг. Энэ жилийн хувьд сонгуулийн явцыг гадаадын 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчид сурвалжилж буй бөгөөд АНУ, Швед, Канад, ОХУ, ХБНГУ, БНСУ, Австрали, БНФУ, Дани, Норвеги, Швейцар улсаас болон олон улсын байгууллагаас нийт 430 гаруй төлөөлөгч ажиглаж байгаа юм. Тэгвэл өчигдрийн сонгуулийн явцын талаархи мэдээллийг дэлхийн мэдээллийн сайтууд хэрхэн дамжуулсныг уншигчиддаа сонирхуулахаар бэлтгэлээ.

### Young Mongolians hope elections will rock 'n' roll political establishment

ULAANBAATAR | BY TERRENCE EDWARDS AND NATALIE THOMAS



A villager (L) fills his ballot paper for the parliamentary elections next to a polling office staff at a polling station on the outskirts of Ulaanbaatar, Mongolia, June 29, 2016.

### Хоёр хүчин хоёулаа хүүхдийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгохоо амлаж байна

Японы Никкэй сайтад ийм нийтлэл тавигджээ. Тус нийтлэлийг монгол хэлнээ бүрэн эхээр нь хөрвүүлбэл, “Монгол Улсын их хурлын бүх нийтийн санал хураалт энэ сарын 29-ний өдөр эхэлсэн бөгөөд 30 гэхэд эцсийн үр дүн тодорхой болно. Авлигын хэрэгтэй холбоотойгоор байр суурь нь гахаж буй эрх баригч Ардчилсан нам хамгийн том сөрөгхүчин болох Ардын намыг ялж, засгийн эрхийг авч чадах эсэх нь анхаараж татаж байна. Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ унасан эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, цаашид нэмэгдсээр байгаа ядуурлын эсрэг улс төрийн бодлого нэн тэргүүний асуудал болоод байгаа юм. Монголын парламентын сонгууль 1990 оны ардчиллаас хойш долоо дахь удаагаа зохион байгуулагдаж буй нь энэ. Энэ удаа парламентын 76 тойрогт 496 нэр дэвшигч өрсөлдөж байна. Парламентын суудлын тоо 76 байдаг бөгөөд бүрэн эрхийнх нь хугацаа дөрвөн жил байдаг. Гэвч гурван ч удаагийн сонгуульд аль ч улс төрийн хүчин олонхи болж чадалгүй эвслийн Засгийн газрыг байгуулан ажиллаж буй. Ардчилсан нам сонгуулийн яг өмнөхөн сонгуулийн пропорциональ системийг халж, нэг тойргоос зөвхөн нэг хүн сонгогдох жижиг мажоритар систем рүү шилжсэн байдаг. Хамгийн сүүлд

явуулсан олон нийтийн санал асуулгаас харахад, авлига, эдийн засгийн хямралтай холбоотойгоор МАН-ын дэмжигчдийн хувьд эрх баригч байх бөгөөд уулзруулах түүхий эдийн хөсрөлт үүссэн 2011-2013 оны үед Дотоодын нийт бүтээгдэхүүн нь хоёр оронтой тоонд хүртлээ нэмэгдэж байв. Гэвч түүний эдийн үнийн уналт, Хятадын эдийн засгийн өсөлт буурсантай холбоотойгоор 2015 онд 2.3 хувь болж буурсан. Үүнээс гадна санхүүгийн нөхцөл байдал нь улам муудаж, Засгийн газраас гаргасан бонд нь эрсдэл хүлээх магадлалтай байгаа. Тиймээс парламентын сонгуульд оролцож буй аль ч улстөрийн хүчний дэвшигч буй мөрийн хөтөлбөр эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, ядуурлыг бууруулахад чиглэж байна. Нийслэл Улаанбаатар хотод гэхэд ажлын байр хайн суурьшсан орон нутгийн залуусын тоо ч нэмэгджээ. Тэдний ихэнх нь тогтсон ажлын байргүй бага орлоготой амьдарч байна. Улаанбаатар хотын зах хэсгийн жижиг толгодуудад гэртэй өрхүүд амьдрах бөгөөд тэднийг гэр хороолол гэж нэрлэдэг. Эрчим хүчний дэд бүтцэд холбогдоогүй зам харилцаа нь ч хөгжил муутай хэвээр. Тэнд амьдрах 32 настай Эрдэнэчимэг гэх эмэгтэйн нөхөр нь ажилгүй, тэдний гэр бүлийн цорын ганц орлого нь Засгийн газраас хоёр хүүхдэд нь олгох халамжийн 40 мянган төгрөг гэнэ. “Орлогынх нь ихэнх нь ахуйн зардалд нь

таардаг. Мөнгө зээлэхгүй л бол амьдрах аргагүй” хэмээн уйлж байна. Сонгинохайрхан дүүрэг хамгийн их буюу 300 мянга орчим хүн амтай, одоо ч 5-6 мянган хүн хашаа барин тус хорооллын тоог нэмжээ. Гэр хорооллынхон Улаанбаатар хотын хүн амын ихэнхийг бүрдүүлэх бөгөөд 700 гаруй мянга байдаг гэсэн мэдээлэл байна. Түүнчлэн тогтсон орлогогүй улирлын чанартай ажил хийдэг ч хүмүүс олон юм билээ. Бүр зөвхөн хүүхдийн тэтгэмжинд болж, хүүхдэд төрүүлсэн хүмүүс ч байдаг гэнэ. Парламентын бүх нийтийн сонгуульд ядуурлын бууруулах чиглэлээр Ардчилсан нам нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулахаа амлаж байгаа бол Ардын нам гэр хорооллын иргэдийн татварын дарамтыг бууруулах амлалтыг өгч байгаа юм. Харин хоёр хүчин хоёулаа хүүхдийн тэтгэмжийг үргэлжлүүлэн олгохоо онцолж байна” гэсэн байна.

### МАН олон суудал авах магадлал өндөр

“Ройтерс” агентлагийн цахим хуудаснаа “Сонгууль улс төрийн элитийг нь “рок-нолдоно” гэдэгт Монголын залуучууд найдаж байна” гэх сонирхолтой гарчиг бүхий мэдээлэл нийтлэгдсэн байв. Тус сайтын сэтгүүлч Т.Эдвардс, Н.Томас нарын бичсэн уг нийтлэлд “Орос, Хятадын дунд хавчуулагдсан ардчиллаасаа насаар төдийлөн ахмад биш Монголын олон залуус эдийн засгийн хямрал хийгээд улс төрийн намуудын

бодлогод сэтгэл дундуур байгаа бөгөөд тэд сонгуулийн үр дүнд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж болзошгүй байгаа юм. Монголын гурван сая хүн амын талаас илүү хувь нь 30-аас доош насныхан бөгөөд тэд Зөвлөлтийн тогтолцоог ардчиллаар сольсон 1990 оны улс төрийн тайван хувьсгалын дараа Холливуд, хип хоп, хэви металын нөлөөн дор өсч торнисон билээ. “Playtime” хөгжмийн наадамд хүрэлцэн ирсэн Хишигдэлгэр хэлэхдээ, “Одоогийн улстөрчдөд би сэтгэл дундуур байдаг. Монголчууд ямар нэг өөр сонголт хийх хэрэгтэй” гэж байв. Ахмад үеийнхэн өөрсдийн хувийн ашиг сонирхлын төлөө эрх мэдлийн төлөө улайрч байна гэх хандлага нийгэмд түгээмэл тархсаны улмаас нам сонгуульд ялалт байгуулж, эрх мэдэлд хүрэхээс жилийн өмнө буюу 2011 онд 17.5 хувьд хүрч байсан эдийн засгийн өсөлт ОУВС-ийн тооцоолсноор энэ жил 0.4 хувь болж буурах төлөвтэй байгаа ажээ. Байгалийн баялаг ихтэй тус улс нүүрс, зэсийн үнэ огцом унаж, Хятадын эрэлт багассан өнөөгийн нөхцөл байдалд хүрсэн байдаг. Зарим албан тушаалтнууд уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчтэй үүсгэсэн маргааны улмаас эдийн засгийн өсөлт буурсан гэж ч үздэг. Хамгийн сүүлийн үеийн санал асуулгаас харахад, сонгогчдын ихэнх хувь нь эдийн засгийн хямралд хүргэсэн Ардчилсан намд итгэл алдарч, хамгийн олон удаа төр

барьсан МАН илүү олон суудал авах магадлал өндөр байна” гэжээ. Ардчилсан нам парламентад олонхи болох нь эргэлзээтэй Японы өдөр тутмын “Асахи” сонины <http://www.asahi.com/> сайтаас сэтгүүлч Хирага Такуяа Монголын сонгуультай холбоотой нэгэн мэдээг бичжээ. Уг мэдээллийг хөрвүүлбэл, “Монгол Улсын парламентын сонгуулийн санал хураалт өнөөдөр /өчигдөр/ болж байна. Сонгуулийн үр дүн маргааш гарах төлөвтэй байгаа бөгөөд өрсөлдөөн ширүүн өрнөж байна. Энэ сонгуульд эрх баригч хүчнээс 38 хүн нэр дэвшиж байгаа бол хамгийн том сөрөг хүчин МАН-аас 30 хүн нэр дэвшиж өрсөлдөөн ширүүн үргэлжилж, засаг солигдож магадгүй нөхцөл байдал үүсээд байна. Сонгуулийн Ерөнхий хорооноос ирүүлсэн мэдээгээр энэ сарын 29-ний өдрийн оройн 17.00 цагийн үед санал хураалтын ирц 55 хувь байв. 495 хүн нэр дэвшсэн парламентын сонгуульд эдийн засгийн өсөлтийг зогсонги байдалд оруулж, авлигын дуулианд холбогдсон Ардчилсан нам парламентад олонхи болох нь эргэлзээтэй байна. Энэ оны гуравдугаар сард явуулсан олон нийтийн санал асуулгаар МАН-ын дэмжигчдийн хувь Ардчилсан намынхаас их байсан юм. Гэхдээ сонгуулийн эцсийн дүн гарах хүртэл эрх баригч хүчний нэр дэвшигчдийн дуулиан үргэлжилсээр байна. Ямартай ч, сонгогчид төрд итгэх итгэлгүй

болсны улмаас Ардчилсан намын байр суурь ганхаж эхлээд байгаа юм. Монголд сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө улс төрийн намууд өөрсөддөө ашигтай байдлаар сонгуулийн хуулийн өөрчлж, пропорциональ системийг халж, жижиг мажоратори системд шилжсэн нь сонгогчдийн итгэлийг алдах нэг шалтгаан болсон гэж ажиглагчид үзэж байна” гэж бичжээ.

### Монголчуудын 60 хувь нь улс орон нь буруу удирдлагаар урагшилж буйг хүлээн зөвшөөрчээ

“theguardian.com” сайтад “Монголчууд эдийн засгийн хүнд цаг үед сонголт хийж байна” гэсэн мэдээлэл нийтлэгджээ. Тус мэдээлэлд “Эрх баригч Ардчилсан нам, сөрөг хүчин Монгол ардын нам хооронд томоохон өрсөлдөөн явагдаж байна. Хоёр намын аль аль нь эдийн засгийг хөгжүүлэхэд мөрийн хөтөлбөрөө чиглүүлсэн байх бөгөөд эрүүл мэнд, боловсролын тогтолцоог сайжруулах гэх мэтээр сонгогчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхээ амлаж байгаа юм. Сонгогчдын хувьд эдийн засгийн хямрал, улс төрийн хөөрхийлөлттэй нөхцөл байдалд бухимдсан хүмүүс 2008 оны сонгуулиар болсон шиг үймээн самуун давтагдах вий гэдэгт санаа зовниж буйгаа илэрхийлж байлаа. Г.Жаргал гэх 25 настай барилгачин эрэгтэй “Улстөрчид бүх амлалтаа биелүүлэх ёстой. Тэднээс шаардах зүйл маш их байна” гэж яриу. Монголын хамгийн том худалдааны түнш Хятад улсын эдийн засгийн эсрэг буурснаар тус улсын өргөн хэрэглээний барааны үнэ өсч, улс орны баялагийг хэн эзэмших талаар улс төрийн хүчнүүд хоорондоо санал зөрөлдсөний улмаас гадаадын хөрөнгө оруулалт буурчээ. Тодруулбал, Хятадын эдийн засгийн өсөлт өнгөрсөн жил 6.9 хувь болж, 2009 оноос хойш хамгийн муу төвшиндөө хүрсэн юм. Тэгвэл сонгуулийн явцын талаар Колумбийн их сургуулийн Монгол дахь ажиглагч Моррис Россабин “Эдийн засгийн хямрал улс төрд үл итгэлцлийг бий болгож байна” гэж онцлон тэмдэглэжээ. Мөн төрбээр “Сонгогчид улс төрийн намуудад итгэхгүй байгаа” гэдгийг нэмж хэлсэн байна. Тавдугаар сард сонгуулийн системийг өөрчилснөөр хоёр том намаас бусад жижиг хүчнүүдийн боломжийг хумисан шийдвэр гарсан юм. Олон улсын бүгд найрамдах институтын мэдээллээр Монголчуудын 60 хувь нь улс орон нь буруу удирдлагаар урагшилж буйг хүлээн зөвшөөрчээ. Судалгаанд оролцсон хүмүүсийн ихэнх нь ажлын байрыг бий болгож, эдийн засгийн сайжруулж чадах улс төрийн хүчинд саналаа өгөхийг хүсч байна.

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2016.06.30

Тендер шалгаруулалтын нэр: Тээврийн хэрэгслийн гэрчилгээ хэвлэж, нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: ЗТЯ-2016/005

Зам, тээврийн яамнаас эрх бүхий тендер оролцогчдоос Тээврийн хэрэгслийн гэрчилгээ хэвлэж, нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь 100,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын талаар дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2014, 2015/

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2014, 2015/ Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь 200,0 сая төгрөгөөс багагүй байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Үнэт цаас хэвлэх тусгай зөвшөөрөл

Тендерийн хамт тендер оролцогчийн санал болгох үнийн дүнгийн 1 % тай тэнцүү төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2016 оны 07 дугаар сарын 29-ны өдрийн 11 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 11.30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй. Дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УЛААНБААТАР ХОТ, СУХБААТАР ДҮҮРЭГ, ЧИНГИСИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨ 11, ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙР 13, ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ, САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.БИЛГҮҮН УТАС-62263182, ФАКС- 11312315

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Өнөөдөр төв замын хөдөлгөөн хязгаарлана

"Найрсаг Улаанбаатар 2016" хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах "BEST OF CLASSIC" сонгодог урлагийн үдшийн цэнгүүн ирэх бямба гарагт Чингисийн талбайд болно. Энэ үдэш Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын уран бүтээлчид дэлхийн болон Монголын сонгодог урлагийн шилдэг бүтээлүүдийг дээжлэн олон нийтэд хүргэдэг билээ. Тус цэнгүүнд Ж.Бизе "Кармен", П.Чайковский "Нойрссон гүнж", "Хунт нуур" Ж.Чулуун "Уран хас", Д.Лувсаншарав "Шивээ Хиагт", Б.Шарав "Чингис Хаан" зэрэг шилдэг бүтээлүүд тоглогдох аж. Тоглолтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улсын дуурь бүжгийн эрдмийн театр хамтран зохион байгуулж байна. Мөн тус цэнгүүнтэй холбогдуулан 2016 оны зургадугаар сарын 30-ны өдрийн 00.00 цагаас долдугаар сарын 02-ны 00.00 цаг хүртэлх хугацаанд Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэр Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайн зүүн талын замыг буюу Соёлын төв өргөөний баруун уулзвараас урагш Централ гаур хүртэлх замын хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлахаар болжээ.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

"Цэрдийн галавын гайхалиг" үзэсгэлэн өнгөрсөн тэртэй гаргагч нээлтээ хийлээ. Үзэгчдийн төв музей барилгын төв танхилаа ашиглаатгай оруулж буйтай холбогдуулан анхны үзлэр болгон Т.Батаар, Цэрдийн үеийн палеонтологийн түүхэн олдворуудыг орчин үеийн шинэлэг техник технологийн тусламжтайгаар гурван хэлжээсийн шийдлээр дэглэн "Цэрдийн галавын гайхалиг" хэлээ үзлэрийг дэглэсэн юм.



## Хүний амь хөнөөсөн гэх этгээдийг илрүүлжээ

Өнгөрсөн бямба гарагт хүний амийг хөнөөж, ухсан нүхэнд хаясан талаар мэдээлсэн. Тодруулбал, иргэдээс Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны ... тоотод айлын хашаанд ухсан байсан жорлонгийн нүхэнд хүний амийг хөнөөн булсан байна гэх мэдээллийг цагдаагийн байгууллагад өгчээ. Мэдээллийн дагуу цагдаагийн байгууллагын алба хаагчид хэргийн газарт очиход тус хороонд оршин суух 42 настай эмэгтэй А-г хөнөөгөөд, цогцсыг нь ухсан нүхэнд булсан байжээ. Тэгвэл цагдаагийн алба хаагчид шуурхай ажиллан, тус хэргийг хэн үйлдсэн болохыг тогтоожээ. Эх сурвалжийн мэдээлж буйгаар 18 дугаар хорооны оршин суугч 24 настай Г гэгч залуу үйлдсэн бөгөөд талийгаачтай ямар хамааралтай хүн болохыг нь нууцалж байна. Дээрх этгээдэд Эрүүгийн хуулийн 91.2 дугаар зүйл анги буюу хүнийг санаатай алах гэсэн зүйл ангиар Эрүүгийн хэрэг үүсгэн Чингэлтэй дүүргийн цагдаагийн хоёрдугаар хэлтэст шалгаж байгаа ажээ.

# “САЙН ХАШАА” ХӨТӨЛБӨРИЙН ЗЭЭЛИЙН 50 ХУВИЙГ УЛСААС ГАРГАНА

## “Сайн хашаа” хөтөлбөрийн зорилго юу вэ. Хэдэн үе шаттай хэрэгжих вэ?

Засгийн газрын 2016 оны зургадугаар сарын 9-ний өдөр “Сайн хашаа” хөтөлбөрийн үйл ажиллагаа, зорилго чиглэлийн талаарх 312 дугаар тогтоол гарсан. Энэ хөтөлбөр маань инженерийн хэсэгчилсэн болон төвлөрсөн дэдбүтэцтэй, амины орон сууц голлосон хороолол хөгжүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах нөхцөлийг бий болгох зорилготой. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр иргэний хувийн өмчийн газар болон амины орон сууцны үнэ цэнэ нэмэгдэнэ. Мөн хот, суурин газрын агаар, хөрс, усны бохирдол буурах давуу талтай. Түүнчлэн өрхийн орлого нэмэгдэж, ажлын байр бий болж, иргэд ая тухтай орчинд амьдрах нөхцөл бүрдэх юм. Өнөөдрийн байдлаар гэр хорооллын иргэд хөрсний болон агаарын бохирдолтой нөхцөлд амьдарч байна. Тэгвэл энэ хөтөлбөрт хамрагдсанаар хөрс, агаарын бохирдолгүй нөхцөлд амьдрах боломжтой болох юм.

## Хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй иргэд хаана хандах вэ?

Хөтөлбөрт хамрагдах иргэд хүсэлтээ аймаг, нийслэлийн хот байгуулалт болон орон сууцны асуудал хариуцсан байгууллагад гаргаж, сайжруулсан гэр хорооллын бүсэд хамаарах тухай тодорхойлолт авах ёстой. Мөн манай хөтөлбөрт оролцогч шаардлага хангасан үндэсний компаниас сонголттой хийж, банкинд хүсэлтээ тавих юм. Харин банк тухайн иргэний эзэлийг сонгосон компанид шилжүүлнэ. Үүний дараа инженерийн шугам, сүлжээний ажил явагдах юм.

## Хөтөлбөрт хамрагдах иргэдэд шалгуур тавьж байгаа юу?

Н.БАТЗАЯА

Монгол Улсын Засгийн газраас гэр хороололд инженерийн шугам сүлжээг шийдэх, цаашлаад хөрс, агаарын бохирдлыг багасгах зорилгын хүрээнд “Сайн хашаа” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа билээ. Тус хөтөлбөрт хамрагдах сонирхолтой иргэд олон байгаа юм. Тиймээс тус хөтөлбөрийн талаар НОСК-ийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Л.Алтанхуягаас зарим зүйлийг тодрууллаа.

...Инженерийн шугам сүлжээний ажил хийгдэх учраас амины орон сууцтай байх ёстой. Харин хөтөлбөрт оролцогч компаниудын хувьд тухайн үйлчилгээг иргэдэд үзүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай...

## Тийм. Гэхдээ иргэдэд хүндрэл учруулахгүйгээ хөтөлбөрийнхөө зорилгын дагуу тодорхой шалгуур тавьсан.Хөтөлбөрт хамрагдах иргэд газар болон үл хөдлөх хөрөнгийн баталгаа гаргаж өгөх хэрэгтэй.

“Сайн хашаа хөтөлбөрт заавал амины орон сууцтай иргэд хамрагдах уу?”

Тэгнэ. Инженерийн шугам сүлжээний ажил хийгдэх учраас амины орон сууцтай байх ёстой. Харин хөтөлбөрт оролцогч компаниудын хувьд тухайн үйлчилгээг иргэдэд үзүүлэх шалгуур үзүүлэлтийг хангасан байх шаардлагатай.

## “Сайн хашаа” хөтөлбөрт хотын аль хэсгийн иргэд хамрагдах вэ. Дахин шинэчлэгдсэн шүү дээ?

Засгийн газрын 312 дугаар тогтоолын өмнө гарсан тогтоолд зорилгот бүсүүдийг зааж өгсөн. Энэ бүсэд тодорхой 10 гаруй байршил тусгасан байсан. Гэвч 312 дугаар тогтоолыг шинэчлэн гаргасан. Энэ дагуу нийслэлийн төвийн болон алслагдсан дүүрэг, хөдөө орон нутгийн гэр хороолол, зуслангийн бүсэд амьдардаг иргэд хамрагдах боломжтой. Ер нь иргэд 100 хувь хамрагдах боломж бүрдээ.

## Зээлийн журам батлагдсан. Зээл авах журмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

“Сайн хашаа” хөтөлбөрт хамрагдах иргэн эхний хоёр жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Айл өрхүүдэд олгох хөнгөлөлттэй зээлийн дээд хэмжээ 10-15 сая төгрөг байхаар тогтоосон. Харин зээлийн таван жилийн хугацаатайгаар олгоно. “Сайн хашаа” хөтөлбөр хэрэгжиж байгаа ч гэсэн иргэдэд дарамт учруулахгүй байх ёстой. Тиймээс иргэдэд олгох зээлийн 50 хувийг төсөвт тусгах замаар улсын болон орон нутгийн төсвөөс хариуцан төлөхөөр зохицууллаа.

## Хэчнээн компани хөтөлбөрт оролцож байгаа вэ?

Бид үндэсний компаниудаа дэмжиж байгаа. Тиймээс хөтөлбөрт оролцогч компаниудад нарийн тоо зааж, хязгаар тогтоогоогүй. Чөлөөтэй оруулж байна. Энэ чиглэлээр ажилладаг үндэсний компаниуд хамрагдах боломжтой. Ер нь зурагдугаар сарын 1-нд “Сайн хашаа” хөтөлбөрийн нээлт хийх үед 80 гаруй үндэсний компаниуд байсан. Нийслэлийн орон сууцны корпорацид бүртгүүлсэн 30 гаруй компани бий. Нийт 120 гаруй үндэсний компани оролцож байна. Нэг үгээр хэлбэл, энэхүү хөтөлбөр нь иргэд болон үндэсний компаниудаа дэмжиж байгаа юм.

## Наадмын сүлд дууг ирэх сард хүргэнэ

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810 жил, Ардын хувьсгалын 95 жилийн ойн баяр наадам болоход 10 гаруй хоног үлдсэн. Тэгвэл Үндэсний их баяр наадамд зориулан “Монгол наадам” хэмээх сүлд дууг гаргасан байна. Наадмын сүлд дууны аяг Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Б.Балхжав, үгийг Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн яруу найрагч Ш.Гүрбазар бичжээ. Харин хөгжмийн найруулгыг хөгжмийн зохиолч Б.Чинбат хийсэн гэнэ. Уг дууг рок поп, сонгодог урлаг, нийтийн дуучид зэрэг нийт 25 дуучид амилуулсан бөгөөд ҮДБЭЧ, ХЦДБЧ, ЦДБЭЧ, УДЭТ-ын уран бүтээлчид хамтран оролцсон аж. Сүлд дууны клип долдугаар сарын 1-нд цацагдах гэнэ.

## Хоёр настай хүүхдийн амийг аварчээ

Барилгын ... давхраас хүн унах гэж байна гэсэн дуудлагын дийлэнхийг хараа хяналтгүй орхисон бага насны хүүхэд эзэлдэг. Тэгвэл өнгөрсөн амралтын өдөр Багануур дүүргийн дайрснаас осол гаргасан аж. Замын цагдаагийн газрын албан хаагчид хэргийн газарт ажиллан ослын шалтгааныг тодруулж байна. Харин дугуйтай иргэнийг түргэн тусламж авч явсан бөгөөд түүний биеийн байдал ямар байгаа нь тодорхойгүй байгаа гэнэ.

## Автобусны жолооч дугуйтай хүн мөргөж, гэмтээжээ

Хорооллын эцсийн “Оргил” худалдааны төвийн урд замд нийтийн тээврийн автобус дугуйтай хүнийг мөргөсөн хэрэг гарчээ. Автобусанд зорчиж байсан эх сурвалжуудын мэдээлж буйгаар хоёр автобус хүнээ булаалцалдан улаан гэрлээр дайрснаас осол гаргасан аж. Замын цагдаагийн газрын албан хаагчид хэргийн газарт ажиллан ослын шалтгааныг тодруулж байна. Харин дугуйтай иргэнийг түргэн тусламж авч явсан бөгөөд түүний биеийн байдал ямар байгаа нь тодорхойгүй байгаа гэнэ.

## СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Үер усны аюулаас болгоомжил

Ус цаг уурын хүрээлэнгээс ирүүлсэн мэдээгээр ойрын өдрүүдэд төв, зүүн зүгийн нутгаар дуу цахилгаантай, аадар бороо орох талаар мэдээллээ. Тодруулбал, өчигдрөөс эхэлсэн бороо үргэлжлэн, ихэнх нутгаар орох юм байна. Иймд ард иргэд амралт аялал, зугаалгаар явахдаа гол усны ойролцоо амарч зугаалахгүй, сонор сэрэмжтэй байх, бага насны хүүхдийг гол усны эрэг дагуу явуулж, тоглуулахгүй байх, хүүхдэд тавих хараа хяналтаа дээшлүүлэх, голуудын усны түвшин нэмэгдэж байгаа тул баталгаатай гүүр, гарам, гарцтай газраар автомашинтай зорчиж аюулгүй байдлаа хангахыг ОБЕГ-аас онцгойлон анхаарууллаа.

# ЗАВСАРЛАГА

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

## ХЯТАДЫН ХЯМРАЛ...



Б.ДАВАА

Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “World photo press-2016” наадмын өдөр тутмын амьдрал төрөлд шилдгээр шалгарсан бүтээлийг өнөөдрийн “Дэлхийн шилдэг гэрэл зураг” булангаараа уншигчиддаа сонирхуулж байна. Хятадын Шаньси мужийн иргэдийн өдөр тутмын амьдралд тохиолдох ердийн л нэг агшныг Канадын зурагчин Кэвин Фрэйер өнгөрсөн оны

арваннэгдүгээр сарын 26-ны өдөр авчээ. Амандаа янжуур зууж тамхины утаа баагиулан гурван дугуйтаа түрэн алхах хятад эрийн цаана хэд хэдэн цахилгаан станцын уурын зуухны яндангаас нүүрсний утаа суунаглаж буй байдал гэрэл зургийн торгон хальснаа нийн буусан байна. Тус бүс нутаг Хятадаа хамгийн их нүүрс үйлдвэрлэдэг бүс нутаг ажээ. Жилдээ 300 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай бөгөөд үүгээрээ улсдаа толгой цохидог байна. Тиймдээ ч, түүхий нүүрсний хэрэглээ өндөр байдаг аж. Гэвч

нүүрстөрөгчийн хий агаарт тархаж, хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх болжээ. Тодруулбал, Хятадын хүн амын нийт нас баралтын 17 хувь нь агаарын бохирдолттой холбоотой байдаг төдийгүй тус улс дэлхийн хамгийн их агаарын бохирдолттой орны тэргүүн эгнээнд бичигдэж байгаа юм. Хятадын агаарын бохирдлын асуудлыг хөндөн тавьсан энэ зураг Дэлхийн хэвлэлийн шилдэг гэрэл зураг шалгаруулах наадамд ирсэн 82951 шилдэг зургаас Өдөр тутмын амьдрал төрөлд шалгарчээ.

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр +24  
Шөнө +10

Нөгөөдөр  
Өдөр +27  
Шөнө +12



**Аргын тооллын:**  
2016 оны 6-р сарын 30,  
Пүрэв гараг

**Билгийн тооллын:**  
Шинийн 26. Зургаан цагаан  
тэнгэстэй Харагчин хонь өдөр.

**Наран ургах/шингэх:**  
05:59 / 21:50

**Үс засуулбал:**  
Жаргал үргэлжид ирнэ.



Тухайн өдөр гахай, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, мал худалдан авах, мал түгээх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсон зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлжлэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

**ХАРААЛ**  
The Mother

WWW.FACEBOOK.COM/TENGISMVIE  
**TEL: 313105**

**ДОРИГИЙН ЭРЭЛД**

2016.6.17

**ГАРАМЫН АМЬДРАЛ**

2016.06.10

**WARCRAFT**  
THE BEGINNING

ТАСАЛБАР ЗАХИАЛГА  
ХҮРГЭЛТТЭЙ БОЛЛОО 1900-1617

### ХОЛЛИВУДЫН СОНИН ХАЧИН

#### Калвин Харрис зурагчдаас зугтаж яваад осолд оржээ



Б.ДАВААХҮҮ

Хөгжмийн ертөнц дэх чадварлаг DJ нарын нэг Калвин Харрис саяхан папарацдаас зугтаж яваад осолд орсон тухай барууны сайтуудад мэдээлжээ. Дуучин Тайлор Свифтэд хаягдсанаас хойш хэрэгт дуртай хэвлэлийнхний нүдэнд байнга өртөх болсон DJ залуу зурагчдаас зугтаж яваад машинтайгаа хана мөргөж, осолд орсон байна. Калвин өнгөрсөн сард найз бүсгүй Тайлор Свифтэд хаягдаж, дуучин бүсгүйн эксүүдийн жагсаалтыг нэгээр нэмсэн байдаг. Харин бүсгүйн хувьд түүнээс салснаас хойш ердөө хоёр долоо хоногийн дараа жүжигчин Том Хиддлтонтой үерхэж, шинэхэн найз залуугийнхаа ээжтэй нь хүргэл танилцаад амжсан. Гэвч гэнэтийн саалалтын дараа хэвлэл мэдээллийн анхаарал DJ залуу руу чиглэж, хаана

ч явсан папарацдын дуранд өртөн, сошиал сүлжээнд бичсэн жиргээ нь хүртэл олны анхаарлыг татах болсон билээ. Тэгвэл саяхан Калвинг машинтайгаа явж байхад нь нэгэн зурагчин хэрэгт дурлан “Одоо та хэнтэй үерхэх бодолтой байна вэ” хэмээн асууж, хэнэг ч үгүй машинд нь суусан аж. Улмаар Калвин зурагчинг машинаасаа буулгасан ч, хойд хаалгаа маргаж хөдөлсний улмаас хана мөргөжээ. Тэрбээр ноцгой гэмтэл аваагүй гэнэ. Үүний дараа залуу өөрийн твиттер хуудастаа “Өнөөдөр нэг зурагчин миний уурыг маш их хүргэлээ. Гэхдээ тэр өөрийнхөө ажлаа л хийж байсан гэдгийг ойлгож байна” хэмээн жиргэсэн байв. Калвин өнгөрсөн сард ч гэсэн осолд орж байсан билээ. Тэрбээр нисэх онгоцны буудал руу явах замдаа осолд орж, эмнэлэгт хүргэгдэж байсан удаатай.